



## САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Дорноговь аймгийн Прокурорын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДГА-2020/134/СТА-ТШЗ

Цахим хуудас:

[www.dornogovi.audit.mn](http://www.dornogovi.audit.mn)

Дорноговь аймаг

2020 он

Тэргүүлэх аудитор: Ч.Ариунаа

Утас: 70522734

Цахим хаяг: [dornogovi@audit.gov.mn](mailto:dornogovi@audit.gov.mn)

Аудитын менежер: Э.Энхцэцэг

Утас: 70523020

Цахим хаяг: [enkhtsetseg.e@audit.gov.mn](mailto:enkhtsetseg.e@audit.gov.mn)

Аудитор:

Т.Мөнхтогтох

Цахим хаяг: [munkhtogtokht@audit.gov.mn](mailto:munkhtogtokht@audit.gov.mn)

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Агуулга

<b>Аудитын гэрчилгээ</b> .....	<b>3</b>
Аудитын тайлан .....	5
2.1. Оршил .....	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	5
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин .....	6
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ .....	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал .....	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар .....	7
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	7
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга .....	8
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	8
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал .....	9
2.12. Шилэн дансны мэдээлэл .....	9
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт .....	9
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл .....	9
Менежментийн захидал .....	10
Аудит хийгдсэн санхүүгийн тайлан .....	11
4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан .....	11
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	12
4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	14
4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	16
4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	17
4.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан .....	18

## Аудитын гэрчилгээ



**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,  
3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр,  
Утас: (705) 2-27-34

2020.02.18 № 1-6/80

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

ДОРНОГОВЬ АЙМГИЙН  
ПРОКУРОРЫН ГАЗРЫН  
ДАРГА С.ЦЭРЭНСАМБУУ ТАНАА

### Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Прокурорын газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Дорноговь аймгийн Прокурорын газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Дорноговь аймгийн Прокурорын газрын 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

### Үүрэг, хариуцлага

Дорноговь аймгийн Прокурорын газар нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.АРИУНАА

## 2.1. Оршил

Дорноговь аймгийн Прокурорын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Дорноговь аймгийн Прокурорын газрын ерөнхий прокурор, хууль цаазын шадар зөвлөх С.Цэрэнсамбуу танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох бараа материалын тайланг дансны ангиллын дагуу гаргаж байх зөвлөмжийг Менежментийн захидалд тусгасан болно.

## 2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Прокурорын газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорноговь аймгийн Прокурорын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 01 дүгээр сарын 20-аас 2020 оны 01 дүгээр сарын 21-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Т.Мөнхтогтох хариуцаж хэрэгжүүлэв.

Дорноговь аймгийн Прокурорын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 2/101 дүгээр бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

## 2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

#### **2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Дорноговь аймгийн Прокурорын газрын үйл ажиллагааны эрхэм зорилго нь Хуулийг дээдэлж, хүний эрх, эрх чөлөө нийтийн эрх ашгийг төлөөлөн хамгаалахад оршино.

Дорноговь аймгийн Прокурорын газрын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Монгол Улсын нутаг дэвсгэрт эрүүгийн болон зөрчлийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг нэг мөр хангуулах хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих, шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцох чиг үүрэг бүхий, хараат бус бие даасан шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхэд оролцогч байгууллага.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоол “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам”
- Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоол “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”
- Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоол “Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам”
- Засгийн газрын 2019 оны 9 дүгээр тогтоол “Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэхэд цалин, урамшуулал олгох журам”
- Засгийн газрын 2019 оны 24 дүгээр тогтоол “Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай”
- Засгийн газрын 2019 оны 277 дугаар тогтоол “Төрийн захиргааны албан тушаалын цалингийн хэмжээ, сүлжээг шинэчлэн тогтоох тухай”

#### **2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус Дорноговь аймгийн Прокурорын газрын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Дорноговь аймгийн Прокурорын газар нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “асолус” программ хангамж ашигладаг байна.

Дорноговь аймгийн Прокурорын газрын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “бага” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

#### **2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитаар Дорноговь аймгийн Прокурорын газрын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 31 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

## 2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлангийн Нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 283,792.6 мянган төгрөгөөс тооцон 2,837.9 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 5,309.4 мянган төгрөгөөр тооцсон нь ажил гүйлгээний цар хүрээ багатай холбоотой болно.

## 2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Дорноговь аймгийн Прокурорын газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 11,220.6 мянган төгрөгөөр буюу 3 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.0	0.0	0.0
Авлага	7,794.1	7,794.1	0.0
Урьдчилгаа	0.0	0.0	0.0
Бараа материал	13,975.5	17,607.8	3,632.3
Үндсэн хөрөнгө	343,143.0	350,731.4	7,588.4
<b>Нийт хөрөнгө</b>	<b>364,912.6</b>	<b>376,133.3</b>	<b>11,220.7</b>
Өр төлбөр	0.0	0.0	0.0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	364,912.6	376,133.3	11,220.7
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>364,912.6</b>	<b>376,133.3</b>	<b>11,220.7</b>

Авлага дансны үлдэгдэл буураагүй байна. Авлага дансны үлдэгдэлд 2018 онд үүссэн, 1 жил болсон 7,794.1 мянган төгрөгийн хувь хүнээс авах авлага байна. Энэ нь тус прокурорын газарт нягтлан бодогчоор ажиллаж байсан Ч.Туултай холбоотой авлага байна. Байгууллагад 7,794.1 мянган төгрөгийн хохирол учруулсан гэмт хэрэг үйлдэж, Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2019 оны 566 дугаар тогтоолоор 3 жилийн хорих ялыг эдэлж байгаа тул тус авлага барагдаагүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 3,632.3 мянган төгрөгөөр өссөн нь аж ахуйн материал өссөнөөс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өссөн нь Улсын Ерөнхий Прокурорын 2019 оны 23 дугаар тушаал “Үндсэн хөрөнгө шилжүүлэх, шилжүүлэн авах тухай”, 2019 оны А/92 дугаар тушаал “Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай”, Улсын Ерөнхий Прокурорын газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2019 оны А/07 дугаар тушаал “Үндсэн хөрөнгө шилжүүлж авах тухай”, 2019 оны А/63 дугаар тушаал “Үндсэн хөрөнгө шилжүүлэх тухай” хөрөнгө шилжүүлэн авсан байна. Үнэ төлбөргүй хүлээн авсан 21,955.6 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдсэн байна. 589,0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж акталж устгасан байна.

Биет бус хөрөнгөд өөрчлөлт ороогүй байна.

Өр төлбөр байхгүй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 376,133.3 мянган төгрөг болж 11,220.6 мянган төгрөгөөр өссөнөөс шалтгаалсан байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт байхгүй.

## **2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөр 2 зориулалтад 489,850.2 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 489,850.2 мянган төгрөгийг бараа үйлчилгээний зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 489,850.2 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 488,320.3 мянган төгрөг буюу 99.6 хувьтай байна. /цалин хөлс болон нэмэгдэл урамшил 376,468.9 мянган төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 47,599.6 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 16,028.3 мянган төгрөг, хангамж бараа материал 18,717.6 мянган төгрөг, эд хогшил худалдан авах 21,087.6 мянган төгрөг, томилолт зочны зардал 2,575.4 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр 5,241.2 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 815.0 мянган төгрөг/ нийт дүнгээр 1,529.8 мянган төгрөг хэмнэгдэж үлдэгдлийг төвлөрүүлсэн байна.

**Нэмэлт төсөв:** Хандив тусламжаар Дорноговь аймгийн Засаг даргын Тамгын газраас 29,984.5 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс ТОБЕМ ХХК-д 29,449.9 мянган төгрөгийг Прокурорын газрын барилгын дотор засварын ажилд зарцуулж, үлдэгдэл 534.6 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

## **2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн**

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 3 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 3 эрсдэл тодорхойлж нийт 6 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 32,817.5 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 30,931.0 мянган төгрөгийн алдааг залруулж, 856.0 мянган төгрөгийн зөрчилд 1 акт тогтоож, 1,030.5 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өглөө.

Аудитаар дараах 856.0 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 856.0 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоолоо. Үүнд:

1. 2019 онд ээлжийн амралтын мөнгийг тооцохдоо ажилтнуудад олгосон хоолны хөнгөлөлтийг оруулж бодсоноор 16 хүнд нийт 856,0 мянган төгрөгийг илүү олгосон нь Хөдөлмөрийн тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.2 дахь заалт “Ээлжийн амралтын олговрыг ажилтны тухайн ажлын жилийн дундаж цалин хөлсний хэмжээгээр тогтооно”, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2005 оны 55 дугаар тушаалаар батлагдсан “Дундаж цалин хөлс тодорхойлох журам”-ын 4 дэх заалт “Ажилтанд олгож байгаа бүх төрлийн /жирэмсний болон амаржсаны, хөдөлмөрийн чадвараа алдсаны, ажилгүйдлийн, тэтгэвэрт гарах үеийн ажилтанд олгох гэх мэт/ тэтгэмжүүд, нөхөх олговор, хөнгөлөлтийн орлого, /унаа, түлш, байр, хоолны үнийн хөнгөлөлт/-ийг ажилтны цалин хөлсний бүрэлдэхүүнд оруулахгүй” гэсэн заалт, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох.

Аудитаар илэрсэн 1,030.5 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 1 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

## **2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал**

Анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

## **2.12. Шилэн дансны мэдээлэл**

Дорноговь аймгийн Прокурорын газрын Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 101 мэдээллийг хугацаанд нь, 46 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 0 мэдээллийг байршуулаагүй байна.

## **2.13. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт**

Нийт 1 зөвлөмж өгснөөс 1 зөвлөмжийг хэрэгжүүлж, зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

## **2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Дорноговь аймгийн Прокурорын газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Дорноговь аймгийн Прокурорын газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.3 дахь заалтын дагуу үнэн зөв илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

### 1 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа

#### 1.1 Илрүүлэлт:

*Бичиг хэргийн материалын эцсийн үлдэгдэлд аж ахуйн материал бүртгээгдсэн байна*

*Энэ нь (Топилуулга ба тодруулга) батламж мэдээгдэлтэй нийцэхгүйгээс гадна Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт 4 дүгээр зүйлийн 4.16 “бараа материалыг ангилж бүртгэхдээ дансны нэгдсэн жагсаалт болон холбогдох УСНББОУС-ыг стандартыг мөрдөнө”, 2014 оны 5 дугаар тушаалын 5 дугаар хавсралт 35 дугаар зүйлийн 35400 хангамжийн материал нь “бичиг хэргийн материал, аж ахуйн материал, сэлбэг хэрэгсэл, түлш шатах тослох материал, барилгын засварын материал, хүнсний материал” гэсэн заалтыг зөрчсөн байна.*

#### 1.2 Эрсдэл:

*Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх, холбогдох хууль, тогтоол, журам, заавар зөрчих.*

#### 1.3 Өгсөн зөвлөмж:

*Сангийн сайдын 2014 оны 5 дугаар тушаалын 5 дугаар хавсралтад заасан дансны нэр төрлийн дагуу хөрөнгийн ангиллыг зөв бүртгэх.*

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

**4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан**

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>21,769,608.42</u></b>	<b><u>25,401,888.42</u></b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	7,794,080.00	7,794,080.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	7,794,080.00	7,794,080.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	13,975,528.42	17,607,808.42
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	13,975,528.42	17,607,808.42
35410	Бичиг хэргийн материал	1,892,700.00	949,700.00
35420	Аж ахуйн материал	8,403,448.00	13,228,728.00
35430	Сэлбэг хэрэгсэл	1,922,360.00	1,922,360.00
35440	Түлш, шатах тослох материал	750,020.42	500,020.42
35470	Бусад хангамжийн материал	1,007,000.00	1,007,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>343,143,025.34</u></b>	<b><u>350,731,439.22</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	343,143,025.34	350,731,439.22
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	324,071,025.34	331,659,439.22
39201	Барилга, байгууламж, орон сууц	297,784,630.00	297,784,630.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-2,394,000.00	-8,547,971.40
39203	Авто-тээврийн хэрэгсэл	67,900,000.00	67,900,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-67,900,000.00	-67,900,000.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	33,930,718.13	48,765,120.13
39206	Хуримтлагдсан элэгдэл	-23,022,385.91	-26,272,190.71
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	40,414,466.00	46,946,666.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-23,149,185.75	-27,431,097.71
39214	Бусад үндсэн хөрөнгө	925,000.00	925,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-418,217.13	-510,717.09
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	19,072,000.00	19,072,000.00
39301	Програм хангамж	917,500.00	917,500.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-917,500.00	-917,500.00
39303	Бусад биет бус хөрөнгө	19,072,000.00	19,072,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>364,912,633.76</u></b>	<b><u>376,133,327.64</u></b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>364,912,633.76</u></b>	<b><u>376,133,327.64</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	364,912,633.76	376,133,327.64
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	330,453,920.10	330,453,920.10
51101	Өмч: - төрийн	330,453,920.10	330,453,920.10
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	-77,399,158.64	-66,178,464.76
51210	Өмнөх үеийн үр дүн	-77,399,158.64	-77,399,158.64
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	11,220,693.88
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	111,857,872.30	111,857,872.30
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>364,912,633.76</u></b>	<b><u>376,133,327.64</u></b>

## 4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>467,887,756.00</b>	<b>542,120,634.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>8,434,556.00</b>	<b>22,285,882.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	8,434,556.00	22,285,882.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	8,434,556.00	22,285,882.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	49,500.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	8,434,556.00	22,236,382.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>459,453,200.00</b>	<b>519,834,752.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	455,953,200.00	489,850,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	455,953,200.00	489,850,200.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	3,500,000.00	29,984,552.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,500,000.00	29,984,552.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>457,643,095.68</b>	<b>530,899,940.12</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>457,643,095.68</b>	<b>530,899,940.12</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	457,427,105.68	528,786,013.86
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	360,340,089.00	376,255,502.74
210101	Үндсэн цалин	206,928,761.00	271,431,599.00
210102	Нэмэгдэл	148,447,478.00	93,139,199.10
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,963,850.00	11,684,704.64
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	43,268,900.00	47,599,600.00
210201	Тэтгэврийн даатгал	29,275,000.00	27,251,700.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,498,500.00	10,862,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,798,800.00	2,529,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	699,700.00	632,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6,996,900.00	6,323,900.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	14,190,004.00	16,028,297.00
210301	Гэрэл, цахилгаан	1,895,295.00	2,132,140.00
210302	Түлш, халаалт	8,161,134.00	11,701,609.00
210303	Цэвэр, бохир ус	4,133,575.00	2,194,548.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	16,665,095.98	16,724,130.00
210401	Бичиг хэрэг	4,639,679.00	5,597,250.00
210402	Тээвэр, шатахуун	5,528,848.80	4,263,800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,403,585.00	3,282,725.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	240,000.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,565,720.00	3,580,355.00
210408	Бараа материал акталсны зардал	287,263.18	00.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	4,132,210.00	19,854,629.00
210602	Тавилга	350,000.00	00.00
210604	Урсгал засвар	3,782,210.00	19,854,629.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	1,624,400.00	2,575,476.00
210702	Дотоод албан томилолт	1,624,400.00	2,575,476.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	2,547,230.00	34,616,191.00

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,175,000.00	34,262,473.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	230,000.00	230,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	101,800.00	101,718.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	22,000.00
210807	Газрын төлбөр	18,430.00	00.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>14,659,176.70</b>	<b>15,132,188.12</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	730,000.00	765,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	13,929,176.70	14,367,188.12
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>215,990.00</b>	<b>2,113,926.26</b>
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>215,990.00</b>	<b>2,113,926.26</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	215,990.00	2,113,926.26
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b><u>10,244,660.32</u></b>	<b><u>11,220,693.88</u></b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	120,589,972.47	00.00
225007	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал	120,589,972.47	00.00
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	-	00.00
		120,589,972.47	
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b><u>110,345,312.15</u></b>	<b><u>11,220,693.88</u></b>

### 4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>459,453,200.00</b>	<b>519,884,252.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>00.00</b>	<b>49,500.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	00.00	49,500.00
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	00.00	49,500.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	49,500.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>459,453,200.00</b>	<b>519,834,752.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	455,953,200.00	489,850,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	455,953,200.00	489,850,200.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	3,500,000.00	29,984,552.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,500,000.00	29,984,552.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>453,229,020.00</b>	<b>519,884,252.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>453,229,020.00</b>	<b>519,884,252.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>453,013,030.00</b>	<b>517,770,325.74</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	368,808,215.00	376,255,502.74
210101	Үндсэн цалин	211,419,739.00	271,431,599.00
210102	Нэмэгдэл	145,334,125.00	93,139,199.10
210103	Унаа хоолны хөнгөлөлт	12,054,351.00	11,684,704.64
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	43,268,900.00	47,599,600.00
210201	Тэтгэврийн даатгал	29,275,000.00	27,251,700.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,498,500.00	10,862,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,798,800.00	2,529,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	699,700.00	632,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6,996,900.00	6,323,900.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	14,180,554.00	16,028,297.00
210301	Гэрэл, цахилгаан	1,895,295.00	2,132,140.00
210302	Түлш, халаалт	9,767,035.00	11,701,609.00
210303	Цэвэр, бохир ус	2,518,224.00	2,194,548.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	16,095,708.00	18,717,630.00
210401	Бичиг хэрэг	4,785,893.00	5,680,400.00
210402	Тээвэр, шатахуун	4,065,850.00	3,950,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,526,765.00	3,591,725.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	240,000.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,477,200.00	5,495,505.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	4,864,303.00	21,087,629.00
210602	Тавилга	350,000.00	00.00
210604	Урсгал засвар	4,514,303.00	21,087,629.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	1,624,400.00	2,575,476.00
210702	Дотоод албан томилолт	1,624,400.00	2,575,476.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	3,170,950.00	34,691,191.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил	2,798,720.00	34,337,473.00

	үйлчилгээний төлбөр хураамж		
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	230,000.00	230,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	101,800.00	101,718.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	22,000.00
210807	Газрын төлбөр	18,430.00	00.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>1,000,000.00</b>	<b>815,000.00</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,000,000.00	815,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>215,990.00</b>	<b>2,113,926.26</b>
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>215,990.00</b>	<b>2,113,926.26</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	215,990.00	2,113,926.26
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b><u>6,224,180.00</u></b>	<b><u>00.00</u></b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>6,224,180.00</b>	<b>00.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>6,224,180.00</b>	<b>00.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>6,224,180.00</b>	<b>00.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	6,224,180.00	00.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b><u>-6,224,180.00</u></b>	<b><u>00.00</u></b>

#### 4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	<b>2018 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	311,381,920.10	94,843,940.55	32,466,347.03	438,692,207.68
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>311,381,920.10</b>	<b>94,843,940.55</b>	<b>32,466,347.03</b>	<b>438,692,207.68</b>
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	19,072,000.00	00.00	-110,345,312.15	-91,273,312.15
C08	<b>2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>330,453,920.10</b>	<b>111,857,872.30</b>	<b>-77,399,158.64</b>	<b>364,912,633.76</b>
D01	<b>2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>330,453,920.10</b>	<b>111,857,872.30</b>	<b>-77,399,158.64</b>	<b>364,912,633.76</b>
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>330,453,920.10</b>	<b>111,857,872.30</b>	<b>-77,399,158.64</b>	<b>364,912,633.76</b>
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	11,220,693.88	11,220,693.88
D09	<b>2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>330,453,920.10</b>	<b>111,857,872.30</b>	<b>-66,178,464.76</b>	<b>376,133,327.64</b>

#### 4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Дүн	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	489,850,200.00	488,320,352.74	1,529,847.26	99.7
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	489,850,200.00	488,320,352.74	1,529,847.26	99.7
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	489,850,200.00	488,320,352.74	1,529,847.26	99.7
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	376,496,700.00	376,255,502.74	241,197.26	99.9
210101	Үндсэн цалин	271,530,300.00	271,431,599.00	98,701.00	100.0
210102	Нэмэгдэл	93,139,200.00	93,139,199.10	00.90	100.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	11,827,200.00	11,684,704.64	142,495.36	98.8
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	47,599,600.00	47,599,600.00	00.00	100.0
210201	Тэтгэврийн даатгал	32,487,700.00	27,251,700.00	5,236,000.00	83.9
210202	Тэтгэмжийн даатгал	3,778,000.00	10,862,000.00	-7,084,000.00	287.5
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,022,400.00	2,529,600.00	492,800.00	83.7
210204	Ажилгүйдлийн даатгал	755,600.00	632,400.00	123,200.00	83.7
210205	Эрүүл мэндийн даатгал	7,555,900.00	6,323,900.00	1,232,000.00	83.7
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	16,500,400.00	16,028,297.00	472,103.00	97.1
210301	Гэрэл, цахилгаан	2,200,000.00	2,132,140.00	67,860.00	96.9
210302	Түлш, халаалт	11,552,400.00	11,701,609.00	-149,209.00	101.3
210303	Цэвэр, бохир ус	2,748,000.00	2,194,548.00	553,452.00	79.9
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	18,720,000.00	18,717,630.00	2,370.00	100.0
210401	Бичиг хэрэг	8,170,000.00	5,680,400.00	2,489,600.00	69.5
210402	Тээвэр, шатахуун	4,200,000.00	3,950,000.00	250,000.00	94.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,150,000.00	3,591,725.00	-441,725.00	114.0
210404	Ном, хэвлэл	200,000.00	00.00	200,000.00	0.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,000,000.00	5,495,505.00	-2,495,505.00	183.2
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	21,554,700.00	21,087,629.00	467,071.00	97.8
210604	Урсгал засвар	21,554,700.00	21,087,629.00	467,071.00	97.8
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	2,600,000.00	2,575,476.00	24,524.00	99.1
210702	Дотоод албан томилолт	2,600,000.00	2,575,476.00	24,524.00	99.1
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	5,428,800.00	5,241,218.00	187,582.00	96.5
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,050,000.00	4,887,500.00	162,500.00	96.8
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	230,000.00	230,000.00	00.00	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	104,800.00	101,718.00	3,082.00	97.1
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	22,000.00	00.00	100.0
210807	Газрын төлбөр	22,000.00	00.00	22,000.00	0.0
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	950,000.00	815,000.00	135,000.00	85.8
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	950,000.00	815,000.00	135,000.00	85.8
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	489,850,200.00	488,320,352.74	1,529,847.26	99.7
1310	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	489,850,200.00	488,320,352.74	1,529,847.26	99.7
131001	Улсын төсвөөс санхүүжих	489,850,200.00	488,320,352.74	1,529,847.26	99.7

#### 4.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>0.00</b>	<b>29,449,973.00</b>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	0.00	29,449,973.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	0.00	29,449,973.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	0.00	29,449,973.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0.00	29,449,973.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>0.00</b>	<b>29400473.00</b>
<b>13</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>		
131105	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	49,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	29,400,473.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	29,400,473.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		